

Maptek Evolution

Шуурхай календарчилсан төлөвлөлт

Стратегийн, уян хатан, оновчтой төлөвлөлт

Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх уян хатан төлөвлөлтийн шийдэл

Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх динамик, шуурхай календарчилсан төлөвлөлт

Maptek™ Evolution ил уурхайн төлөвлөлтийн хэрэгсэл нь уурхайн үйл ажиллагаатай зөрчилдэхгүйгээр төслийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд корпорацийн түвшний төлөвлөлтийн оновчлолын аргачлалыг ашигладаг.

Maptek Evolution нь уурхайн амьдралын мөчлөгийн явцад бодит, өндөр үнэ цэнэтэй календарчилсан төлөвлөлтийг гүйцэтгэх ил уурхайн төлөвлөлтийн цогц шийдэл юм.

Уурхайн үнэлгээ, үйл ажиллагааны үе шатанд зориулж хамгийн зөв сонголтыг хийхийн тулд төлөвлөлтийн хувилбаруудыг харьцуулан үнэлдэг. Ингэснээр уурхайн төлөвлөлтийн инженерүүд нь зардлыг бууруулах, нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх үр ашигтай төлөвлөлөгөөг сонгох боломжтой болдог.

Хэд хэдэн календарчилсан төлөвлөлтүүд

Evolution нь нэг симуляцийн дүнд хэд хэдэн календарчилсан төлөвлөгөөний хувилбаруудыг боловсруулдаг бөгөөд компаний төлөвлөлтийн мөчлөгийг хамарсан төлөвлөгөө боловсруулахдаа бүх өгөгдлийн бүрдлийг ашигладаг. Ингэснээр уурхайн үйл ажиллагааны хугацаанд хүдрийн хэмжээ, түүнд агуулагдах агуулгыг тогтмол байлгах боломжтой. Evolution программын тусламжтайгаар хүдрийн блокийн аль хэсэг олборлолтонд өртсөн, хаашаа тээвэрлэх зэргийг мэдэж авах бөгөөд уурхайн хүрээнд хүдрийг орхихгүй ажиллах боломжийг олгоно.

Бодит, төвөгтэй асуудлыг шийдвэрлэх нь

Хэрэглэгчид ойлгомжтой интерфэйсийн ачаар календарчилсан төлөвлөлтийн тохиргоог хялбархан хийх боломжтой. Үүлэн тооцоололд суурилсан процесс нь дүн шинжилгээ хийх боломжтой хэд хэдэн хувилбаруудыг бусад ажлаа хийж байх зуур давхар ачааллан гаргах боломжтой.

Хялбар ажлын урсгал

Evolution нь нэг өгөгдлийн эх үүсвэрийг ашиглан стратегийн төлөвлөлтөөс богино хугацааны төлөвлөлтүүр хялбархан шилждэг. Evolution программыг сурахад болон тохиргоо хийхэд хялбар бөгөөд төлөвлөлтийн үр дүнг хэдхэн цагийн дотор гаргаж авах боломжийг хэрэглэгчдэд олгодог. Уурхайн тээвэрлэлтийг төлөвлөлтийн явцад оруулж өгснөөр төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх оновчтой календарчилсан төлөвлөлтийг гаргаж авахад чиглэдэг.

Боломжууд

> Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх: Төслийн үнэ цэнийг захын агуулгын аргачлалыг ашиглан 30% хүртэлх хувиар ихэсгэх боломжтой.


> Бүтээмжийг нэмэгдүүлэх: Evolution нь бусад программын шийдлүүдтэй харьцуулахад илүү зардал багатай бөгөөд төлөвлөлтийг арав дахин хурдан боловсруулдаг.

> Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх: Evolution нь оновчтой тээвэрлэлт болон хөрсний овоолгыг боловсруулах төлөвлөлтийн цогц шийдэл бөгөөд ингэснээр программ хангамжийн зардлыг 30%-иар бууруулдаг.

> Зардлыг багасгах: Оновчтой тээврийн чиглэл нь календарчилсан төлөвлөлтийн эхэн үед зардлыг бууруулж цаашид 5-10% хүртэлх хувиар төслийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг.

> Хөрс хуулалтыг оновчлох: Хөрсний овоолгын эцсийн хэлбэрийг оновчлосноор овоолгыг шилжүүлэх зардлыг багасгаж, нөхөн сэргээлтийн ажлыг эрт эхлэх, нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрийг эрт суллах боломжтой болно.

> Программын боломжит нэвтрүүлэлт: Эхлэл зардал болон явцын өөрчлөлт шаардлагагүй төлөвлөлтийн шийдэл. Төлөвлөлтийг шуурхай эхлэх боломж.



Яагаад Maptek Evolution ашиглах хэрэгтэй вэ?

Хэрэглэгчид төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх уурхайн календарчилсан төлөвлөлт, бодит төлөвлөгөөг хүсдэг.

- > Тохиргоо хийх болон хэрэглэхэд хялбар
- > Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх
- > Ордын нөөц ашиглалтыг ихэсгэх
- > Үйл ажиллагааны зардлыг багасгах
- > Үр дүнтэй шийдвэр гаргалт
- > Компаний төлөвлөлтийн мөчлөгтэй уялдуулах
- > Уурхайн тээвэрлэлтийг багтаасан нэгдсэн шийдэл
- > Хүдэр жигдрүүлэлтийн зорилгот хэмжээнд хүрэх
- > Цогц календарчилсан төлөвлөлт
- > Блокд хуваан төлөвлөлтийг боловсруулах
- > Төлөвлөлтийг хянах боломж

Cloud суурилсан, 64-bit зэрэгцээ боловсруулалт
Сар тутмын богино хугацааны календарчилсан
төлөвлөлтөөс урт хугацааны төлөвлөлтийг гүйцэтгэх
Нэг өгөгдөл ашиглан богино болон урт хугацааны
төлөвлөлтийг гүйцэтгэх
Геологийн модельд суурилсан дундажлаагүй өгөгдөл
CSV, BMF төрлийн файлыг импортлох
Газрын гадаргын өгөгдөл импортлох
DXF, CSV төрлийн файл болон ашиглалтын хугацаа
бүрийн төлөвлөлтийн зургийг экспортлох
Гурван хэмжээст блок модель болон төлөвлөлтийг
бүрэн харуулах
Календарчилсан төлөвлөгөөг нарийвчлан харах
Захын агуулгын оновчлол
Ашиглалтын хугацаа бүрт өөр өөр захын агуулга
тооцох
Wizard болон тусгай бэлдсэн тайлан боловсруулах
Олон модель, процесс болон хүрэх цэгүүд
Тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн календарчилсан
төлөвлөлт
Динамик олон төрлийн хүдрийг овоолгод хураах,
жигдрүүлэх
Тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн оновчлол
Өнөөгийн цэвэр үнэ цэнийн (NPV) оновчлол
Software-as-a-Service (программ хангамжийг
үйлчилгээ хэлбэрээр хүргэх)

Evolution гэж ямар программ бэ?

Evolution бол ил уурхайн үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх шуурхай, корпорацийн түвшний шийдэл юм. Уурхайн дунд, урт болон стратегийн төлөвлөлт нь нөөц ашиглалтыг оновчлон үйл ажиллагааны зардлыг бууруулдаг.

Evolution программыг ашиглаж эхлэхэд хэр хугацаа шаардагдах вэ?

Evolution нь шууд ашиглаж болох ил уурхайн төлөвлөлтийн шийдэл бөгөөд эхлэх зардал мөн ашиглалтын үеийн тохируулга шаардлагагүй. Ажиллаж буй бүхий л төсөл болгонд ижил бөгөөд хэрэглэхэд хялбар интерфэйстэй. Хэрэглэгчид Evolution-ийг ашиглахад тусгай программын чадвар шаардлагагүй бөгөөд хэдхэн цагийн дотор төлөвлөлтийг гаргаж авах боломжтой. Үүлэн суурьтай боловсруулалт нь хэрэглэгчдийг өөр ажил хийж байх хооронд дүн шинжилгээ хийх боломжтой хэд хэдэн төлөвлөлтийн хувилбаруудыг бэлэн болгосон байдаг. Шинэ төлөвлөлт өмнөх төлөвлөлтүүдээс хялбархан салаалах боломжтой.

Хэд хэдэн уурхайгаас олборлосон бүтээгдэхүүнд хүдэр жигдрүүлэлт хийх боломжтой юу?

Evolution-ий динамик олон жигдрүүлэлт, хүдрийн овоолгын аргачлал нь ашиглалтын аль ч хугацаанд төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх оновчтой хүдрийг гаргаж авах боломжийг олгодог. Тус программын шийдлээр стратегийн ашиглалтын төлөвлөгөөг уурхайн үйл ажиллагааны үе шатуудтай холбосон байдаг.

Ашиглалтын хугацаа бүрээр хувьсах хүдрийн захын агуулгыг тооцож болох уу?

Evolution нь ашиглалтын аль ч хугацаанд динамикаар захын агуулгыг тооцдог бөгөөд хэрэглэгчид хамгийн ашигт нөөцийг олборлох боломжтой.

Блок моделийг шууд төлөвлөлт хийхдээ ашиглаж болох уу?

Evolution-ий нэг давуу тал бол Vulcan-ий блок моделийг (.bmf) шууд ашиглах явдал юм. Ингэснээр төлөвлөлтийн инженерууд блок модельд байгаа бүхий л хэрэгтэй мэдээллийг ашиглаж төлөвлөлтийг хийх боломжтой болдог. Мөн хэрэглэгчид бусад төрлийн төлөвлөлтийн блок моделийг .csv формат бүхий файл болгон программд хялбархан импортлон оруулж ашиглах боломжтой. Газрын гадаргын өгөгдлийг мөн импортлон оруулах боломжтой.

Тээвэрлэлтийн тоног төхөөрөмжүүдийг хэрхэн оновчлох вэ?

Ил уурхайн үйл ажиллагааны зардлын ихэнхи хэсгийг тээврийн зардал эзлэдэг. Evolution нь уурхайн төлөвлөлт, хөрсний овоолгыг зэрэг оновчлодог бөгөөд овоолгод хөрс буулгах ажлыг оновчлосноор тээвэрлэлтийн зардлыг бууруулах боломжийг олгодог. Тус программ нь уурхайн аль хэсгээс блок олборлох, тээвэрлэлтийн хугацаа, тээврийн циклийн хугацаа болон зарцуулах шатахууны хэмжээ зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг авч үздэг.

Блок модель өөрчлөгдсөн тохиолдолд төлөвлөлт дагаад өөрчлөгдөх үү?

Блок моделийн мэдээлэл өөрчлөгдөх эсвэл шинэчлэгдэхэд блок модель болон төлөвлөлт хоорондын холбоо нь хэрэглэгчдэд олон асуултанд хариулах боломжийг олгох бөгөөд ингэснээр төлөвлөлт хэзээд үнэн зөв байх нөхцлийг бүрдүүлдэг. Геологийн модель өөрчлөгдөхөд төлөвлөлт мөн шинэчлэгддэг.

Ямар үр дүн гардаг вэ?

Evolution нь хөдөлгөөнт байдлаар харуулах, хоорондоо хялбархан солилцох нарийвчилсан төлөвлөлтийг үүсгэдэг. Системчилсэн ашиглалтын төлөвлөгөө болон өндөр үнэ цэнэтэй, бодит олборлолтын үе шатууд нь уурхайн ашиглалтын хугацааны үйл ажиллагааг оновчлох болон ашиглалтын хугацаа бүрийн бүтээгдэхүүний чанарт хүрч ажиллахад тусладаг. Хэрэглэгчид .dxf болон .csv форматаар блок модель болон ашиглалтын хугацаа

Evolution Strategy бол төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг (NPV) нэмэгдүүлж, хүдрийн захын агуулгын оновчлолыг боловсруулдаг стратегийн төлөвлөгч юм.

Evolution Origin

Evolution Origin нь уурхайн нийт ашиглалтын хугацааны төлөвлөлтөөс богино хугацааны календарчилсан төлөвлөлт хүртэлх бүхий л төлөвлөлтийн нарийвчилсан хувилбаруудыг боловсруулдаг. Мөн Evolution Strategy-аар үүссэн оновчлолын үзүүлэлтүүдийг ашиглах боломжтой.